

7

ЭЛИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА
ЯДУУРЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Сувд

1. Монгол улсын эдийн засаг, нийгмийн байдал

1990-ээд оноос эхэлсэн зах зээлийн тогтолцоонд шилжих шилжилтийн үеийн эдийн засгийн гол зорилго нь хуучин тогтолцоог халж зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үндсэн нөхцөлүүдийг бүрдүүлэх явдал байлаа. 1990 оноос өмнөх үеийн монголын эдийн засгийг ерөнхийд нь дүгнэж хэлбэл ЭЗХТЗ-ийн хүрээнд хоршиж ажиллахад чиглэгдсэн өрөөсгөл бүтэцтэй өөрөө өөрийгөө нөхөн хангах чадваргүй Зөвлөлт холбоот улсаас ихээхэн хэмжээгээр хараат байдалтай байлаа. Импортоор их хэмжээний бүтээгдэхүүн авдаг бөгөөд бие даасан үндэсний үйлдвэрлэл сул хөгжилтэй байсан.

Ийм бүтэцтэй эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжих үед Зөвлөлт холбоот улс задарч зөвлөлтийн зээл тусламж зогссон нь манай эдийн засагт хүнд цохилт болсон юм. ЗХУ-ын тусламж авахаа больсоноос ҮНБ-ний 30% тай тэнцэхүйц $\text{үйлжүүлэх өндөр өсөлт}$!

Үүний зэрэгцээ ЭЗХТЗ үгүй болсноор өөрөө бие даан амьдрах чадваргүй эдийн засагт гадаад худалдааны таатай нөхцөл алдагдаж импорт багасахад шийдвэрлэх нөлөө үзүүлэв. Энэ байдлыг ЭЗХТЗ-ийн гишүүн байсан бусад орнуудтай харьцуулахад Монгол улсын худалдааны нөхцөл хамгийн ихээр муудаж ноцтой хохирол хүлээсэн юм гэж НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрт дурьджээ.²

Монгол улс хэрэгцээт бүх нефть бүтээгдэхүүн машин техник сэлбэг хэрэгсэлээ импортоор авдаг байсан бөгөөд 1992 он гэхэд импорт 1998 оныхтой харьцуулбал

¹ Монгол дахь ядуурал ба зах зээлийн эдийн засагт шилжих үе. Кейт Гриффин тэргүүтэй НҮБХХ-ийн мэргэжлийн хэсгээс засгийн газарт бэлтгэсэн илтгэл. 1994 оны 4-р сар. 8-р тал.

² НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. Монгол Улс ядуурлыг багасгах стратеги, тулгуур баримт бичиг. Улаанбаатар хот. 1993. 2-р тал.

50 илүү хувиар буурч үндэсний эдийн засагт болон ард түмний амьдралд нэн хүнд байдлыг бий болгосон юм¹. Шилжилтийн үеийн эхэнд учирсан энэ байдалд зөвхөн гадаад хүчин зүйл нөлөөлөөд зогсоогүй дотоод хүчин зүйлүүд ч нөлөөлсөн. Юуны өмнө өөрөө өөрийгөө нөхөн хангах чадваргүй өрөөсгөл бүтэцтэй, дэд бүтэц хөгжөөгүй байсан нь өнөөдөр ч эдийн засгийн өсөлтөд нөлөөлсөөр байна.

Зах зээлийн мэдлэгтэй мэргэжилтэй боловсон хүчин дутмаг буюу үндсэндээ байгаагүй. Өөрчлөгдөж байгаа шинэ нөхцөл байдлыг мэдэрч микро түвшинд үйлдвэрлэлийг зохион байгуулах, макро эдийн засгийн бодлогыг зохицуулан удирдах ажилтан бэлэн биш байсан.

Харин зах зээлд шилжих явцад удирдах ажилтан, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэгдэж байна. Гэхдээ энд зориуд тэмдэглэхэд өмнөх тогтолцооны үед олсон хамгийн дэвшилттэй тал бол хүний хөгжлийн үзүүлэлт сайжирсан явдал юм гэж НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, "Хүн хүчний талаарх илтгэл"-д дурьджээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хүн бүрт тэгш хэрэглээг бий болгохыг зорьж байсан нь бэлэнчлэх сэтгэлгээг төлөвшихөд хүргэж, амьдралын бүх нөхцлийг бэлнээр шаардах хандлагатай болсон бөгөөд сайтар хөгжсөн нийгмийн хамгааллын тогтолцоо задран унасан нь хүн амын амьдралын түвшинд сөргөөр нөлөөлсөн юм.

Энэ бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Монгол улсын засгийн газар эдийн засгийг тогтворжуулах, бүтцийн өөрчлөлт хийх зорилгоор 1993 оноос 3 жилийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн юм.

Бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх болон эрчимжүүлэх хөтөлбөр нь эдийн засгийн гадаад дотоод тэнцвэрийг хангах замаар эдийн засгийн үр ашгийг сайжруулж цаашдын өсөлтийг хангах, урьдчилсан нөхцлийг бэлтгэх үүднээс, зах зээлийн механизмд нийцсэн өндөр үр ашигтай экспортын салбарыг хөгжүүлэхийн тулд гол нь хувийн сектор, гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих замаар дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

1993 оноос хувийн хэвшлийн үйл ажиллагаа ялангуяа үйлчилгээний болон худалдааны салбарт эрс нэмэгдсэн нь аж үйлдвэр хөдөө аж ахуйн салбар дахь үргэлжилсэн уналтыг нөхөж байлаа. Үнэ тариф болон валютын ханшийг чөлөөлөх, худалдааны тогтолцоог шинэчлэх, өмч хувьчлалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зэрэг олон арга хэмжээнүүдийг хамарсан бүтцийн бодлого нь улсын хэмжээнд бараа үйлчилгээний нийлүүлэлт нэмэгдэхэд тус дөхөм болсон юм.

Эдийн засгийн өсөлтийг хангах замаар ард түмний аж байдлыг дээшлүүлэхийн тулд, үнэ худалдаа эдийн засгийн аливаа үйл ажиллагааг чөлөөлөх, үйлдвэр аж ахуйн газруудын бие даасан байдлыг бүрэн хангах замаар эдийн засгийг тогтворжуулах авдал чухал юм. Үүний тулд өмч хувьчлалыг тууштай явуулж, хувь хүмүүс үйлдвэр аж ахуйн газрууд өмчийн эрхийн хамгаалалттай байх нөхцлийг хангахад анхаарч байна.

¹ Монгол улсын статистикийн эмхтгэл. 1997. 214 дэх тал.

Өнгөрсөн хугацаанд хувьчлал ба хувийн өмчийн үүсэл хөгжлийн дүнд бүрэн ба бүрэн бус хувийн эзэмшилтэй үйлдвэрүүдийг оролцуулан тооцвол хувийн сектор ҮНБ-ний 64%-ийг үйлдвэрлэж байна. Энэ нь 1990 оны үе дэх 10 хувьтай харьцуулбал асар их өөрчлөлт юм. Өмнөх тогтолцооноос уламжлан үлдсэн нэг зүйл бол Монголын экспортын барааны нэр төрөл цөөн, тэдгээр нь дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай байна. Жнь: нийт экспортын барааг талаас илүү хувийг нь эзэлдэг зэс, ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ 30%-иар унахад Монголын эдийн засгийн өсөлтийн хурдац төлөвлөж байснаас 2, 3 хувиар унасан байна.

Манай орны хувьд үндэсний хуримтлал нь нэн бага, харин гадаадын санхүүжилт өндөр байна. Гадаад санхүүжилт бүхэлдээ буцалтгүй тусламж хөнгөлөлттэй зээлийн хэлбэртэй байгаа бөгөөд энэ нь зээл тусламжийн хэмжээнд найдаж болохгүй учраас өөрийн дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх шаардлага өссөөр байна.

1.1. Эдийн засгийн өсөлт ба нийгмийн асуудал

Хүн ардын аж амьдралын түвшинг дээшлүүлэх нэг эх сурвалж нь эдийн засгийн өсөлт мөн. Гэхдээ эдийн засгийн өсөлтийг хангаж байж дараа нь нийгмийн асуудлыг шийднэ гэсэн дэс дараалал цаг хугацааны шууд утгаараа байж таардаггүй.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах явцыг шилжилтийн үедээ байгаа манай орны хувьд авч үзвэл цаг хугацаа хөрөнгө хүч, анхаарал шаардсан асуудал бөгөөд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжиж байгаа өнөө үед урьд өмнө байгаагүй нийгмийн сөрөг үр дагавар, тухайлбал ядуурал, ажилгүйдэл үлэмж хэмжээтэй болсон нь эхлээд эдийн засгийн өсөлтийг бүрэн хангаж байж дараа нь нийгмийн асуудлыг бүрэн шийдэх боломжгүйг харуулж байна. Сүүлийн үед 90-ээд оны эхэн үетэй харьцуулбал эдийн засгийн өсөлт тогтворжих явдал ажиглагдаж байна.

Харин ядуурал, ажилгүйдлийн хэмжээ өсөж байгаа нь эдийн засгийн өсөлт өөрөө аяндаа нийгмийн асуудлыг шийдвэрлэж чадахгүйг харуулж байна. Иймд эдийн засгийн өсөлтийг хангах тэр явцдаа амьдралын түвшинг дээшлүүлэх, ядуурал ажилгүйдлийг бууруулах асуудлыг зэрэгцүүлэн шийдвэрлэх хэрэгтэй болж байна.

Хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх ядуурлыг бууруулах гол арга зам бол ажлын байрыг шинээр бий болгох, үр ашигтай бүтцийг бий болгон бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээний чанарыг сайжруулж хүн нэг бүрт хүрч үйлчлэх хүртээмжийг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах явдал юм.

Шинэ ажлын байр бий болгох нь амьдралын төвшин доогуур, ядуу амьдралтай, эсвэл огт ажилгүй хүмүүсийг амьдралын баталгаатай болгодгоороо давуу талтай.

Гэхдээ зүгээр л нэг ажлын байрыг бий болгох гэсэн идэвхигүй хэлбэрээс, үр ашигтай бүтээмжтэй ажлын шинэ байрыг бий болгох, идэвхитэй бодлогыг хэрэгжүүлэх нь

чухал юм.

Ийм бодлогын дотор нэг мэргэжлээс нөгөөд шилжихэд болон огт мэргэжилгүй хүмүүст шинэ мэргэжил эзэмшүүлж дадлага олгох тусгай сургалтыг ч зохион байгуулах, ийм сургалтанд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Ийм сургалтуудыг зохион байгуулж байгаа хувийн хэвшлийнхэнд дэмжлэг үзүүлэх, татвараас хөнгөвчлөх гэх мэт урамшлийн арга хэмжээнүүдийг авч болох юм.

Малчин өрхүүдийн дотор амьдрал дорой, цөөн малтай, эсвэл огт малгүй иргэд байгаа нь тэдний амьдрал ахуйг дээшлүүлэхэд зориулж нэр заасан тодорхой ажил зохион байгуулахыг шаардаж байна. Манай оронд эрс тэрс уур амьсгалтай, цаг агаарын хүнд үе олонтой тохиолддог, байгалаас хараат байдлаар мал аж ахуй хөгжиж байгаа болохоор нийт малчдын эрх ашигт нийцсэн мал эмнэлэгийн үйлчилгээ, хөдөө аж ахуйн техникийн үйлчилгээ, цаг агаарын хүнд үед туслах тусламжийн үйлчилгээнүүдийг зохион байгуулбал энэ нь малчин ардын аж амьдралын түвшинг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр болох юм.

Түүнчлэн малчдын бодит амьдралыг нарийвчлан судалсны үндсэн дээр төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг тодотгон хэрэгжүүлэх нь чухал болно. Энэ нь зөвхөн амьдралын төвшин доогуур хүмүүст ач холбогдолтой төдийгүй ерөөс хүн амын амьдралыг баталгаатай болгож, хөдөө орон нутагт тогтвортой амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

1.2. Эдийн засгийн өсөлтийн тогтворжих хандлага

Макро эдийн засгийн өсөлт бууралтыг харуулах үндсэн үзүүлэлт болох ДНБ-ийг авч үзвэл 1992 онд -9.5% буюу бууралт дээд цэгтээ хүрч 1993 оноос бууралт саарч, 1994 онд анхны өсөлт +2.3% байснаа 1997 онд +3.3% 1998 онд +3.5% болж тогтворжих хандлага ажиглагдаж байна.

1990-1993 онд дэлхийн нийт бүтээгдэхүүн эрс буурсантай холбоотойгоор нэг хүнд ноогдох ДНБ 25%-иар буурч мөн энэ үед ДНБ-д хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин ойролцоогоор гурав дахин багассан байна. Тэгвэл 1994-1997 онуудад ДНБ өсч, нэг хүнд ноогдох ДНБ аажим өсч эхлэв. Өөрөөр хэлбэл ДНБ-ний жилийн нийт өсөлт дунджаар 3% болж, нэг хүнд ноогдох ДНБ-ний өсөлт сүүлийн жилүүдэд нэг хувь болов.


Энэ хугацаанд ДНБ-ний салбарын бүтцэд нилээд өөрчлөлт гарав. Салбарын бүтцэд гарсан өөрчлөлтийг сүүлийн жилүүдээр авч үзье.

ДНБ-ний салбарын бүтэц (оны үнээр хувиар)¹

| | 1994 | 1995 | 1996 | 1997 | 1998 |
|--------------------------------------|------|------|------|------|------|
| ДБН | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| Аж үйлдвэр | 30.5 | 32.4 | 20.6 | 24.1 | 24.1 |
| Хөдөө аж ахуй | 36.9 | 36.7 | 36.8 | 33.5 | 32.8 |
| Барилга | 2.1 | 2.7 | 3.8 | 3.4 | 3.5 |
| Тээвэр | 4.6 | 3.4 | 4.7 | 5.2 | 5.3 |
| Холбоо | 1.2 | 1.2 | 1.1 | 1.4 | 1.4 |
| Худалдаа, материал техникийн хангамж | 11.7 | 12.3 | 18.3 | 18.9 | 18.9 |
| Үйлчилгээ | 10.5 | 11.2 | 14.7 | 13.9 | 14.0 |
| Бусад | 2.4 | 0.1 | | | |

Хөдөө аж ахуйн салбар ДНБ-д эзлэх хувиараа нэлээд тогтвортой байгаа нь ХАА-н салбар түүний дотроос мал аж ахуйн салбар, эдийн засгийн уналтад бага өртсөнтэй холбоотой. 1997 оны байдлаар нийт малын тоо толгой 1990 оныхтой харьцуулбал 120 орчим хувь хүртэл өссөн байна ("Монголын эдийн засаг" шилжилтийн эдийн засгийн гарын авлага УБ, 1990 он, 253 дахь тал). Ийнхүү хөдөө аж ахуйн салбар ДНБ-д эзлэх хувиараа нэлээд тогтвортой байхад аж үйлдвэрийн эзлэх хувь буурах хандлагатай байна. Хэдий тийм боловч дотоодын нийт бүтээгдэхүүн 1994 оноос хойш өсөх хандлагатай болж макро эдийн засаг бүхэлдээ тогтворжих хандлагатай болж байна. Энэ тогтворжилтод нийгмийн асуудлуудыг хэрхэн шийдэж байгаа нь эргээд нөлөөлөх нь дамжиггүй.

Макро тогтворжуулалт гэдэг нь хувийн хэвшил ажлаа итгэлтэй төлөвлөж болохуйц тогтвортой нам, инфляцийн нөхцөлд эдийн засгийн хүчин чадлаа бүрэн ашиглан эрчимтэй хөгжих нөхцөл буюу дотоод тэнцвэр үүнтэй уялдан үүссэн импортынхоо хэрэгцээнд захиргааны элдэв хязгаарлалтгүйгээр экспортын орлого болон өөрийн хэт дарамтад орохгүй, харьцангуй тогтвортой болж чадах хэмжээний гадаад тэнцвэрийг зэрэг хангахыг хэлнэ.²



Макро тогтворжуулалтад эдийн засгийн бодлогоор тэдгээрийн зохицуулалт чухал нөлөөтэй. Эдийн засгийн бодлогуудын үр дүнд сүүлийн жилүүдэд инфляц буурч байна. Тухайлбал 1992 онд 325.05%, 1993 онд 183.00% байсан бол 1994 онд 66.3%, 1995 онд 53.1%, 1996 онд 53.2%, 1997 онд 17.5%, 1998 онд 6% байв. 1999 онд 10% болсон байна. Ийнхүү үнийн төвшний өсөлт буурч байгаа хэдий ч янз бүрийн нэр төрлийн бараа үйлчилгээний үнийн төвшний ихсэлт харилцан адилгүй байна.

¹ Монгол улсын статистикийн эмхтгэл. 1998. Улаанбаатар 1999. 97 дахь тал.

² Монгол улс XXI зуунд. Эдийн засаг нийгмийн шинэ бодлого. 1997. 121 дэх тал.

Жишээ нь 1998 онд орон сууц, түлш цахилгааны үнэ 9.2%, соёл боловсролын барааны үйлчилгээний үнэ 19.7%, гутал хувцас, бүс барааных 35.5%, эм тариа эмнэлэгийн үйлчилгээнийх 2.6%-иар тус тус өссөн байна.

Аливаа улс орны хувьд хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй байдаг. Шинээр үйлдвэрлэл үйлчилгээг нээж хөгжүүлэх, хуучин ажиллаж байсан үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөхөд хөрөнгө оруулалт шууд нөлөөтэй. Өнөөдөр хөрөнгө оруулалтын дийлэнхи хувь нь гадаад эх үүсвэрээс харьцангуй бага хэсэг нь дотоодын хуримтлалаас бий болж байна. Ийм нөхцөлд гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж үр ашгийг дээшлүүлж, энэ үндсэн дээр хэмнэлт бий болгож ажиллах нь чухал юм. Гадаадын хөрөнгө оруулалт нь өөрөө шинжлэх ухаан техникийн орчин үеийн ололт, тэргүүний технологийг оруулж ирдэгээрээ ач холбогдолтойг үгүйсгэх аргагүй.

Макро эдийн засгийн тогтворжилтод хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг өндөрсөж байна. ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа нь хувийн хэвшлийн бүх нөөц бололцоог бүрэн нээж, илрүүлсэн хэрэг хараахан биш юм. Хувийн хэвшлийн хүрээ салбар бүрт харилцан адилгүй байна.

Жишээ нь 1998 оны байдлаар хөдөө аж ахуйд 78.8%, худалдаа үйлчилгээний салбаруудад 90 орчим хувьтай байна. Үүнтэй зэрэгцүүлбэл газар тариалан, бөөний худалдаа, барилгын компаниудад хувийн хэвшлийн эзлэх хувь бага байна. Иймд хувьчлалыг цаашид гүнзгийрүүлэх, хувийн өмчийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг тууштай авч хэрэгжүүлэх шаардлага өсөж байна. Зах зээлийн нөхцөлд хувийн хэвшлээр дамжин гадаадын хөрөнгө оруулалт орж ирдэг сайн талтай. Жишээ нь 1996 оны дунд үе гэхэд Монгол улсад нийтдээ 138 сая долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирсэн нь чамлахааргүй тоо юм.

Ер нь хувийн хэвшил, жижиг бизнесийг төрөөс дэмжиж, хөгжих бололцоог бүрдүүлэх нь юу юунаас эрхэм зүйл болж байна. Шинэ тутам үүсч байгаа бизнесийг дэмжих гол нөхцөл бол макро эдийн засгийн тогтворжуулалт, хууль эрхзүйн орчин, зах зээлийн үнэ, ханшийн либералчлал юм. Үүний зэрэгцээ өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх орчинг бүрдүүлэх нь үйлдвэрлэл үйлчилгээ сэргэж гол нөхцөл болж байна.

2. Ядуурлын зарим асуудал

Орчин үед хүний хөгжил, ядуурлын асуудлуудад ихээхэн анхаарал хандуулж хэвлэж нийтлэх, судлах цар хүрээ өргөсөж байгаа хэдий ч ядуурлын талаарх нэгдсэн ойлголт хараахан төлөвшөөгүй байна. Хүн амын дотор ядуурал нэмэгдэж байна гэж ярихдаа ихэвчлэн хүн амын орлогын талаас тайлбарлаж байгаа нь ядуурлын талаар өрөөсгөл ойлголт бий болоход нөлөөлж байна. Ядуурал нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг бөгөөд эдийн засаг улс төр, нийгмийн бодлогын үр дүнгээр тодорхойлогддог. Ийм ч утгаараа ядууралтай хийх тэмцэл нь дэлхий

дахинаа энэ зууны хамгийн гол асуудлуудын нэг болж байна. Ядууралтай тэмцэх аливаа бодлогын хүрээнд юуны өмнө ядуурлыг өөрийг нь зөв тодорхойлж гаргах нь чухал юм.

Ядуурал бол олон талтай. Ядуурлыг ганц утгаар тодорхойлохоос илүү олон талаас нь иж бүрэн тодорхойлох нь амьдралын олон өнгө аястай нийцдэг. Өөрөөр хэлбэл ядуурал гэдэг нь зөвхөн эд хөрөнгө орлого дутагдсанаас болдоггүй. Түүнээс хавьгүй өргөн хүрээтэй ойлголт юм. Ядуурал нь хувь хүн, айл өрхийн үндсэн хэрэгцээгээ хангахад зайлшгүй шаарлагатай байгаа хоол хүнс, хувцас болон бусад үйлчилгээ дутагдсанаас үүсч болдог. Нийгмээс ядуурлыг дотор нь туулийн ба харьцангуй материаллаг ба материаллаг бус, объектив ба субъектив, анхдагч ба хоёрдогч, ухамсартай ба ухамсаргүй, цаг үеийн буюу түр зуурын, байнгын гэх мэтээр ангилж авч үздэг байна.

Монгол улсын үндэсний статистикийн газраас 1998 онд явуулсан монголын хүн амын амьжиргааны түвшний судалгаанд ядуурлын талаарх нэгдсэн ойлголт тодорхойлолт одоо хүртэл үгүйлэгдсээр байна гэж тэмдэглээд, туулийн, харьцангуй, субъектив гэсэн ядуурлын ойлголт давамгайлж байдаг ба эдгээр нь чухам юу вэ гэдгийг тодорхойлсон нь нэг алхам урагш ахисан ололт гэж бодож байна.

Ядууралтай тэмцэх бодлогын хувьд ч харилцан адилгүй байдаг бөгөөд 1998 оны дэлхийн хөгжлийн илтгэлд дэлхийн банкнаас ядуурлыг "...амьдралын наад захын стандартыг хангах чадваргүй бол" гэж тодорхойлсон нь хамгийн ерөнхий утгаараа оновчтой тодорхойлолт гэж үзэж болох юм. (Дэлхийн хөгжлийн илтгэл 1990 он, 26 дахь тал) Бидний төсөөлж байгаагаар ядуурал гэдэг нь хүний хэвийн амьдралын нөхцөл болсон хоол хүнс цэвэр ус, орон гэр, хувцас хунар зэрэг хэрэгцээг хангахад шаардагдах эд хөрөнгө орлогын дутагдал, орлого болон эд хөрөнгө олж авахад хэрэглэгдэх боловсрол, мэргэжлийн дутагдал, байгаа орчин нөхцөлөө өөрчлөх боломж, эрх хэмжээний дутагдал юм. Үүнээс үзвэл ядуурал нь эдийн засаг, улс төрийн асуудлуудыг ч өөртөө багтааж байгаа өргөн хүрээтэй ойлголт юм.

"Монголын хүний хөгжлийн илтгэл 2000"-д дурьдсанаар сүүлийн жилүүдэд нийт улсын хэмжээнд ядуурлын эзлэх хувь хэмжээ мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй буюу ядуучуудын тоо бага зэрэг нэмэгдсэн боловч ядуурлын гүнзгийрэл даамжирсаар байна. Шилжилтийн өнөө үед орлогын ерөнхий хэмжээ буурахын хамт тэгш бус байдал ихэссэнийг ҮС-ийн коэффициентээс харж болно. 1995-аас 1998 оны хооронд монголд ҮС-ний коэффициент 0.31-0.35 болж өсчээ. Туулийн ядуурлын хувьд 1995 оны байдлаар 821000 ядуу хүн байсан бол 1998 онд 863000 болж ядуу хүн амын тоо 5%-иар өсчээ. Харьцангуй ядуурал буюу ядуучуудын тархалтын хувьд авч үзвэл монголын ядуурал хөдөөд биш, харин хот суурин газарт ялангуяа аймгийн төвүүдэд нийт хүн амын тоо буурсан ч ядуучуудын тоо илүү өндөр хувьтай байна. Ядуучуудын тэн хагас нь ганц бие эхчүүд, 0-15 насны хүүхдүүд, өндөр настан байна.

Ядуугаасаа болж сурах боломж дутагдах, сургууль завсардах үзэгдэл газар авч байгаа нь ядуурал түр зуурын байлаа ч хүүхдийн сурах боломжийг хаагдуулж байгаагаараа цаашид байнгын ядуурлыг бий болгох аюултай байна. Ялангуяа хотын төвд ядуу өрхүүдийн хүүхдийн сургууль завсардалт харьцангуй өндөр байгаагийн ирээдүйн үр дагаварыг анхаарах шаардлагатай болжээ. Энэ утгаараа өнөөгийн ядуурал бол түр зуурын гэж ярьж дүгнэж байгаа хүмүүстэй санал нийлэхгүй байгаагаа тэмдэглэе.

Ийнхүү цөөнх хэдэн баримтаас үзэхэд ядуурал, хамрах хүрээ тархалт гүнзгийрлийн хувьд нэмэгдэж байгааг ядууралтай хэт тэмцдэг бодлогын хувьд улам сайжруулж төрийн болон төрийн биш байгууллагуудын хүчийг нэгтгэх, хувь хүний хариуцлагыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарал тавих хэрэгтэй байна. Ядуурлыг бууруулах гол хүчин зүйл нь эдийн засгийн хувьд эдийн засгийн өсөлт, макро эдийн засгийн тогтворжилт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бүтцийн шинэчлэлт мөн. Бидний дээр тодорхойлсон эдийн засгийн өсөлтийн өнөөгийн хүрсэн төвшин ядуурлыг бууруулах түвшинд хараахан хүрч чадаагүй буюу цаашдын тогтвортой өсөлтийг шаардаж байна. Үүний тулд хүн амын амьжиргааг тогтвортой болгох. Стратеги төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх. Амьдралын түвшинг ахиж дэвших, (уналт доройтол) болон эдийн засгийн бодлогуудын хэрэгжилт, уялдаа холбоо үр нөлөө тогтоох, эдийн засгийн бодлогууд нь эдийн засгийн өсөлтийн хурдацийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж чадаж байгаа эсэхэд үнэлэлт өгч, ядуурал болон түүний үр дагавар дахь эдийн засгийн механизмийн нөлөөллийг тодорхойлох нь эдийн засагч судлаачдын хувьд хойшлуулшгүй зорилт болж тавигдаж байна.

Ашигласан материал

1. Хүн амын амжиргааны түвшний судалгаа. УБ, 1999 он.
2. Монгол улс XXI зуунд. Эдийн засаг, нийгмийн шинэ бодлого. УБ, 1997 он.
3. Монголын эдийн засаг. Шилжилтийн эдийн засгийн гарын авлага. УБ, 1999 он.
4. Монголын хүний хөгжлийн илтгэл. 2000. Монгол улсын засгийн газар, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр.
5. Статистикийн эмхтгэл. 1999 он.
6. Монгол: Шилжилтийн эдийн засаг дахь ядуурлын үнэлгээ. 1996, Дэлхийн банкны баримт бичиг.
7. Отчет о мировом развитии. 1995.